



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2016 оны 12 дугаар
сарын 12-ны өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6 дахь хэсэг, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.2 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын Мэргэжлийн зөвлөлийн 2016 оны 11 дүгээр сарын 23-ны өдрийн хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Монгол Улсын хилээр нэвтрүүлэхэд тавих хяналтын тусгай журам”-ыг хавсралтын ёсоор баталсугай.

2.Тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Гаалийн хяналт, шалгалтын газар /Э.Мөнхөө/-т үүрэг болгосугай.

3.Энэ тушаал гарсантай холбогдуулан Гаалийн ерөнхий газрын даргын 2003 оны 348 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.АСРАЛТ

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2017 оны 1 дүгээр сарын 30-ны өдрийн 3692 дугаарт бүртгэв.

**МАНСУУРУУЛАХ ЭМ, СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ БОДИС,
ТЭДГЭЭРИЙН ТҮҮХИЙ ЭДИЙГ МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР
НЭВТРҮҮЛЭХЭД ТАВИХ ТУСГАЙ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэх, гаалийн хяналт тавих, гаалийн бүрдүүлэлт хийх, хууль бусаар нэвтрүүлэх явдлыг таслан зогсоохтой холбогдсон харилцааг зохицуулахад энэ журмын зорилго оршино.

1.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэхэд Мансууруулах эмийн тухай 1961 оны НҮБ-ын Конвенци, Сэтгэцэд нөлөөт бодисуудын тухай 1971 оны НҮБ-ын Конвенци, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хууль, Гаалийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү журмыг мөрдөнө.

Хоёр. Улсын хилээр нэвтрүүлэхэд тавигдах шаардлага

2.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Засгийн газраас тусгайлан тогтоосон хилийн боомтоор нэвтрүүлнэ.

2.2.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуульд заасны дагуу аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, Эрүүл мэндийн яамнаас олгосон “Мансууруулах, сэтгэцэд нөлөөт эмийн импорт/экспортын лиценз”-ийг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ.

2.3.Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн импорт, экспортын лицензийн нэг хувийг Гаалийн ерөнхий газрын гаалийн хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ. Гаалийн хяналт, шалгалтын асуудал хариуцсан нэгж лицензийн мэдээллийг харьяа гаалийн газар, хороо /цаашид “гаалийн байгууллага” гэх /-д хүргүүлнэ.

2.4.Судалгаа, шинжилгээний зориулалтаар мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг улсын хилээр нэвтрүүлэхэд Засгийн газрын 2003 оны 196 дугаар тогтоолыг мөрдөнө.

Гурав. Гаалийн хяналт, бүрдүүлэлт

3.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг Гаалийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3 дахь хэсэгт заасан бичиг баримт, экспортлогч, импортлогч талуудын хооронд байгуулсан гэрээг үндэслэн гаалийн бүрдүүлэлт хийнэ.

3.2.Гаалийн байгууллага холбогдох бичиг баримтыг хүлээн авч, лицензэд заасан мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн нэр, хэлбэр, тун, тоо хэмжээ, /баглаа боодол/ үйлдвэрлэгчийн нэр, хилээр нэвтрүүлэх хугацаа, нэвтрүүлэх хилийн боомт зэргийг гаалийн мэдүүлэгтэй тохирч байгаа эсэхийг шалгана. Гаалийн байгууллага лицензийн эх хувийг гаалийн мэдүүлэгтэй хамт хавсаргаж, архивт хадгална.

3.4.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн лицензийг улсын хилээр нэвтрүүлэхэд нэг удаа ашиглана.

3.5.Лицензэд заасан мэдээлэл мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг нэвтрүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын бичиг баримт болон бараатай зөрсөн тохиолдолд гаалийн болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

3.6.Мансууруулах болон сэтгэцэд нөлөөт эмийн гаалийн бүрдүүлэлт хийсэн мэдээг гаалийн байгууллага тухай бүр Гаалийн ерөнхий газрын гаалийн хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгжид ирүүлнэ.

3.7.Гаалийн хяналт, шалгалт хийхдээ шаардлагатай тохиолдолд хөдөлгөөнт хяналт болон мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисыг илрүүлэх тоног төхөөрөмж, техник хэрэгсэл ашиглах, мөн мэргэжлийн чиг үүргийн байгууллагын төлөөллийг байлцуулан хийнэ.

Дөрөв. Хориглох зүйл

4.1.Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.5, 13.1.7, 13.1.8 дахь заалтуудыг мөрдөж ажиллана.

Тав. Бусад

5.1.Улсын хилээр нэвтрүүлж байгаа мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодис, тэдгээрийн түүхий эдийг эрх бүхий төрийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл болон экспортлогч, импортлогч талуудын байгуулсан гэрээнд заасан нэр, төрөл, тоо хэмжээнээс илүү байвал гаалийн болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

5.2.Энэ журмаар зохицуулаагүй бусад харилцааг Гаалийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.